



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 01 сарын 08 өдөр

Дугаар А/06

Булган сум

Газар эзэмших эрх шилжүүлэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1, 38.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Иргэн Л.Нарантуяа (ГЮ58022801)-гийн Булган сум 5 дугаар баг Д.Дамбын 6 дугаар гудамж 211 тоотод байршилтай 6308003678 нэгж талбар бүхий худалдаа, үйлчилгээний зориулалтаар эзэмшиж буй 371 м² газрын газар эзэмших эрхийг Д.Мөнхбаяр (ГА87091971)-т, Ч.Жамбалдорж (ГЮ44030219)-ийн Булган сум 5 дугаар баг Хатанбаатар С.Магсаржав 4 дүгээр гудамж 400 тоотод байршилтай 6308003602 нэгж талбар бүхий худалдаа, үйлчилгээний зориулалтаар эзэмшиж буй 929 м² газрын газар эзэмших эрхийг Ж.Батзориг (ГЮ84091111)-т тус тус шилжүүлсүгэй.

2. Д.Мөнхбаяр, Ж.Батзориг нартай газар эзэмшүүлэх гэрээг шинэчлэн байгуулж, гэрчилгээжүүлэн газар эзэмшилтэд хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ү.Бямбасүрэн)-т даалгасугай.

3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2016 оны А/373 дугаар захирамжийн Л.Нарантуяатай холбогдох хэсэг, 2023 оны А/109 дүгээр захирамжийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА  Б.АРИУН-ЭРДЭНЭ

